



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/774

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, 20 дугаар зүйлийн 20.1.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны хуралдааны III/05 дугаар тогтоол, 2023 оны XVII хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 17/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн "Алдарт эх"-ийн одонтой ээжүүдийг дэмжих, тэдний нийгмийн оролцоог хангах зорилгоор 16 сум, 1 тосгоны төлөөллийг оролцуулан "Одонтой ээжүүд"-ийн зөвлөгөөнийг 2023 оны 11 сарын 18-ны өдөр зохион байгуулсугай.

2. Зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

